



## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 14

Улаанбаатар

### Л.ЭНХНАСАНГ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.2.2 дахь заалтын “ж” хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Тахько (ХК) компанийн Гүйцэтгэх захирал Лутаагийн Энхнасанг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Л.ДАШМЯГМАРЖАВ



## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 15

Улаанбаатар

### Д.МИНЖМААГ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.2.2 дахь заалтын “ж” хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Даваадашийн Минжмааг Тахько (ХК) компанийн Гүйцэтгэх захирлаар 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөр томилж, “онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Л.Энхнасан)-д зөвшөөрсүгэй.
2. Гүйцэтгэх захирлын ажлыг хүлээлцэх комиссыг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Л.Дашмягмаржав
Комиссын гишүүд:	Л.Энхнасан Г.Төгөлдөр Э.Чулуунтогтох Б.Сольрагчаа

4. Ажлыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны дотор хүлээлцүүлж, санхүүгийн болон бусад холбогдох тооцоог хийж дуусгахыг Комиссын дарга (Л.Дашмягмаржав)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Л.ДАШМЯГМАРЖАВ



## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 16

Улаанбаатар

### Ш.МӨНХ-ОЧИРЫГ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмын 4.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Шаравын Мөнх-Очирыг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу Ш.Мөнх-Очиртой холбогдох тооцоог хийхийг Ерөнхий нягтлан бодогч (Б.Сольрагчаа)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Л.ДАШМЯГМАРЖАВ



## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 17

Улаанбаатар

### Э.ЧУЛУУНТОГТОХЫГ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.2.10 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Эрдэнэчулууны Чулуунтогтохыг Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн томилсугай.
2. Э.Чулуунтогтохтой хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Л.Энхнасан)-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Л.ДАШМЯГМАРЖАВ